

ундааны алийг таалах вэ гэж мэхэсхийн асуух ажээ. Биднийг зоог барьж байхад, Крэнстон найр тавьж, Р. Доул, Р. Бирд зэрэг сенаторуудтай танилцуулахад тэд монголын академийн төлөөлөгчид бидэнд гүнээ талархаж байгаагаа илэрхийлж билээ.

(Үргэлжлэл бий).

ШАНДУ ХОТЫН ТУУРИЙГ ҮЗСЭН НЬ

Ч. ДАЛАЙ

Түүхийн ухааны доктор

Юан гүрний үеийн монгол хаадын зуслан хэмээн алдаршсан Шанду хотын туурийг үзэхээр Шилийн хотоос шулуун хөх хошууны төв орохоор гарлаа. ӨМӨЗО-ны гадаад харилцааны газрын ажилтан Алтанбагана, Шилийн хотын гадаад харилцааны газрын ажилтан Лю нар Зоригт бид хоёрыг дагалдан явлаа. Цэлмэг сайхан өдөр байлаа. Тэр зүг чиглэсэн засмал замаар бидний суусан тэрэг 70 орчим миллийн хурдтай давхиж байв. Замын хажуугаар бут сөөг ургасан довтолгод, бүрд, шанд хосолсон говь хээр нутаг үргэлжилнэ. Юан гүрний үеэс Монгол хаад ноёдын сүргийг маллаж онд тарган оруулдаг хайлаас, тоорой, сухай, бөөргөлжин буйлс зэрэг говийн ой шугуй бүхий Баян-бүрд байдгийг сонссон, Газрын талд ороход тэрхүү Баянбүрд үргэлжлэв. Одоогийн байдлаар эртнийхээ дүр төрхийг алдаж мод нь сийрэгжиж элсэнд идэгдэж байгаа байдалтай харагдав.

Дөрвөн цаг хагас хиртэй явж Шулуун Хөх хошууны төвд ирж зочид буудалд байрлав. Хошууны дарга Дамба, соёлын танхимын эрхлэгч Чимид, «Шандын ундрал» сэтгүүлийн эрхлэгч Чимгээ, буудлын орлогч дарга Хас болон Чингэс товчоон номын зохиогч нэрт түүхчин Сайшаал нар угтан учрав. Тэр оройжингоо монголын түүхийн сонирхолтой сэдэв, газар орны талаар хууч ярилцахад аян замын алжаалыг нэгэнт мартаж, харин монголчууд мөн ч урт удаан хугацааны баялаг сайхан түүхтэй үндэстэн юм даа гэдэг бодол зүрх сэтгэлийг минь байнга эзэмдэх байв. Тэр нутагт төрж өссөн түүхчин Сайшаал гуай монголын түүхийн газар орны талаар нэлээд зүйл тайлбарлан ярив. Мөн ч их юм үзсэн, ой ухаан сайтай хүн болох нь мэдэгдэж байв.

Бидний очсон шөнө зөөлөн бороо оров. Маргааш нь цэлмэг сайхан өдөр байлаа. Энэ бол тавдугаар сарын 24-ний өдөр юм. Өглөө 9 цагт Шанду хотын туурь үзэхээр гурван тэргэнд хуваагдан сууж хөдөлцгөөв. Өргөн уудам Шанду-гийн шар талаар давхихад энд тэндгүй үхэр мал идээшилж байв. Адуу, үхэр, хонь малын бэлчээрт тохиромжтой байрын нутаг юм. Урт нарийхан Шанд гол нь 108 булгаас эх авдаг гэж нутгийн настнууд ярьдаг ажээ. Шандугийн шар тал 70 км үргэлжилдэг юм байна. Намар цагт шар цэцгээр битүү хучигддаг гэнэ. Иймээс түүхэнд

алтан лянхуа цэцэгт тал хятадаар «Цзин лян чуань» хэмээн алдаршсан юмсанжээ.

1899 оны 5-р сарын 24-ний өдөр Оросын алдарт монголч эрдэмтэн А. М. Позднеев Шанду-дээд нийслэлийн туурийг шинжлэн судлахаар ирж Юаний дээд нийслэлийн тууриар аялсан тэмдэглэл» гэсэн тэмдэглэл бичиж үлдээсэн байдаг билээ. Бид бас тавдугаар сарын 24-нд очсон нь гайхалтай.

Хошууны төвөөс Шанду-гийн туурь хүртэл 25 км ажээ. Ойртох тутам том том дов бүхий хэрэмийн үлдэгдэл, барилгын ор тодрон харагдсаар байв. Бидний суусан тэрэг мөдхөн Шанду голыг гатлан хотын туурьт хүрэлцэн ирэв. Тэрэгнээс буунгуут юуны өмнө алс орчин тойрныг ажиглан харав. Хойт талын хар уулыг Хорго гэдэг гэнэ. Өмнө зүгт Түшээ хайрхан уул харагдана. Орой дээр нь Юан гүрний үед одон орон судлах оргил байжээ. Монгол хаадын цэргийн харуулын овоо эргэн тойрны уулын оройд харагдана. Ийм овоо 108 байдаг ажээ. Хотын өмнүүр Шанд гол урсаж байна. Хот байгуулсан газрын байцыг ажиглавал эрт үед монголчууд хот балгас барихдаа үнэхээр газар сонгон олж чадаж байжээ гэдэг сэтгэгдэл аяндаа төрнө. Энэ нь монгол хаад, ноёдын зуслан, зугаа цэнгээний газар байж болохоос гадна монгол хятадын хоорондох харилцааны чухал уулзвар газар болж байжээ.

Монгол гүрний далай хаан Мөнх хятад нутагт дайтаж явах үедээ Хархорум төвтэй монгол орныхоо төрийн хэргийг дүү Аригбөхөөр хамааруулан үлдээсэн билээ. 1259 онд Мөнх хаан хятад газар таалал төгсөв. Их хааны шарилыг эх нутаг дахь Их Хориг тийш чандлан залсан юм. Шарилын нүсэр хөсгийг Хубилай угтан золгож хаан ахынхаа гэрээсийг дагахыг андгайлъя гэж тангараглан хэлсэн юм гэдэг.

Уул ёсондоо Мөнх хааны гэрээс ёсоор буюу эзэн улсынхаа төрийн хэргийг хамаарч байсны хувьд Аригбөх их хааны ширээ залгамжлах хууль ёсны эрх бүхий байжээ. Гэтэл умарт хятадын нутгийн хэсгийг захиран баримтлах үүрэг хүлээж явсан Хубилай ноён хятад бичгийн түшмэдийн заавар зөвлөлгөөг дагаж Монголын их хааны ширээ булаан авах нарийн төлөвлөгөө боловсруулж хүн хүч эд агуурсын их бэлтгэлийг урьдчилан хийсэн байв. Чухам ийм зорилгын үүднээс Хархоринтой өрсөлдүүлэн Кайпин хотыг байгуулж нийслэлэн суухаар шийдсэн ажгуу. Ингээд 1260 онд Монгол улсын их хааныг өргөн сонгох Их Хуралдайн уламжлалт ёсыг сүрхий гэгч нь хөсөрдүүлж шинээр байгуулж эхэлсэн Кайпин хотод өөрийгөө хууль ёсны гадна Монголын хаан хэмээн өргөмжилсэн ажээ. Чухам ингэж 1260 онд монгол нутагт хоёр хаан зэрэг суусан түүхтэй билээ. Үүнээс болж ах дүү хоёрын хооронд цус урсгасан дайн гарч монгол ард түмнийг урт хугацаанд дайны хөлд чирэгдүүлсэн билээ. 1263 онд Кайпин хотыг Шанду монголоор дээд нийслэл болгон нэрийджээ.

Хубилай хаан 1265 оноос Шанду хотод албан ёсоор нийслэлэж дээд нийслэлийн Сэргийлэн засах яамны сайдыг тохоон томилжээ. 1280 онд Дээд нийслэлийг ерөнхийлөн захирах яамыг байгуулжээ. 1281 онд Шандугийн засаг захиргааг өөрчлөн зам болгосон байна. 1288 оны нэгэн түмэн хятад, хотон цэрэг ирүүлж Шанду-гийн орчим газар тариалан эрхлүүлж, заримыг нь хотыг өргөтгөн барих ажилд оролцуулжээ. 1290 онд дахин нэг мянган ажилчин, уран дархчуудыг нэмэн авч ирэх хотыг барьж байгуулах ажилд дайчилсан гэх мэт мэдээ сэлт сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг. Энэ мэтээр Шанду хотыг өргөтгөн барих ажил тасралтгүй үргэлжилсээр байжээ.

Шанду нь зүүнээсээ баруун тал хүртэл 1280 м, урдаасаа хойт зах хүртэл 1320 м тэгш дөрвөлжин хэлбэртэй хот байжээ. Хот нь гадна хот, цэцэрлэг хот, дотор хот гэх гурван үндсэн хэсгээс бүрэлдэж байжээ. Гадна хот нь урдуур хойгуураа тус бүр нэг том хаалга, зүүн, баруунаараа тус бүр хоёр жижиг хаалгатай байжээ. Баруун хойт талд барьсан цэцэрлэг хотын хэрмийн өмнө тал нь 770 метр урт дундаа нэг хаалгатай байжээ. Гадна хэрмийн дотор бас хааны ан хийдэг газар байжээ. Хотын гадна талын хэрмийг голдуу чулуугаар барьжээ. Тэр үеийн хэрэм ханын үлдэгдэл болох богинохон хэсэг одоо хүртэл угийн төрх байдлаараа үлдсэн нь нэн их сонирхолтой юм. Хэрмийн завсраар нэг том улиас ургажээ. Тэдгээрийг Юаний үеийн хэрэм, мод гэж тайлбарлаж байв. Гадна хэрмийн суурь 4 м өргөн өндөр нь 5-7 метр байжээ. Бид дотор хотыг голдуу үзэж сонирхов. Тэнд их хааны орд харш болон бусад олон барилга, сүм дугана байсны туурь байна. Хөх, цэнхэр, ногоон, шар өнгийн ваарын хэлтэрхий болон хөх өнгийн тоосгоны хагархай энд тэнд хөглөрнө. Хотын гол орд харшийг 30х 15 том тоосгоор барьсан юм байна. Шанду хотын тухай бичсэн түүх судар, Шар өвгөний дурьдатгал болон Сайшаал, Дамба зэрэг нөхдийн тайлбарласнаас үзвэл тэнд их хаан, тэдний хатдын суудаг 5—6 том орд байжээ. Орднуудыг тойруулан барьсан гоёмсог олон барилга байшин, сүм дугана байжээ. Тухайлбал Алтан гадас танхим, гэгээн гэрэлт орд, Алтан суврага, Алтан барын толгойт харш, Үнэрт тагт гэх мэт олон барилга байшин байжээ.

Шанду хотод бурхны сүм хийдээс гадна лал, христосын сүм хийд байжээ. Марко Пологийн тэмдэглэлд Монголын хаад дөрвөн их шашинг адилхан үзэж, ёслол үйлддэг байсан хэмээн тэмдэглэсэн байдаг билээ.

Шанду хот бол тухайн үедээ Монголын төр улсын чухал нэгэн төв байсан юм. Тэнд дотоод бичгийн яам, Нууц цэргийн яам, Сэргийлэн хамгаалах газар, Өртөө албаны яам, Хууль цаазны яам, Шадар цэргийн явдлын яам зэрэг 70 шахам албан газар байжээ. Түүнээс гадна монгол хаадын эрдэнэсийн сан, амуу будааны агуулах зоос мөнгөний сан, зэр зэвсгийн сан зэрэг 12—13 сан хөмрөг байсан гэнэ. Бас хааны эмнэлгийн хороо, Хотын эмнэлгийн газар, хааны эмийн сан зэрэг эм эмнэлгийн газар байжээ. Дотор хотын төв дунд зүүн, баруунаараа 55 м, урдуур, хойгуураа 8 м өндөр шороон тавцан байна. Энэ нь их хааны суудаг гол ордны туурь бололтой. Хүмүүс Хубилайн их орд ч гэж ярьдаг ажээ. Түүн дээр гарвал хотын эргэн тойрон цөм харагдана. Овгор шороонд дарагдсан тэрхүү туурь дотроос өмхөрсөн тулгуур багана, дээврийн ваар, ханын тоосго цухуйж харагдана. Дотор хотын хэрэм урдуур, хойгуураа тус бүр 480 м, баруун, зүүн талаараа 540 м урт ажээ. Дотор хот нь өмнө талдаа нэг том хаалгатай, зүүн баруун талдаа нэг нэг жижиг хаалгатай байжээ.

Одоогийн байдлаар хотын ерөнхий дүр төрх алдагдаагүй байна. Яг ийм үед нарийн хамгаалалтанд авч зарим хэсгийг нь сэлбэн засвал бололцоотой байгаа мэт.

1358 онд хятадад гарсан бослогын цэрэг Шанду хотыг дайрч эзлээд эвдлэн шатаасан тухай мэдээг түүх сударт тэмдэглэсэн байдаг. Бас тэр үед Монгол жанжин Цагаантөмөр Шанду хотыг хамгаалж бослогын цэргийг хөөн дарж байсан баримт сэлт ч бий. 1358 оноос хойш Монголын хаад ноёд Шанду-д зусахаар огт ирээгүй юм. 1368 онд Тогоонтөмөр хаан Бээжингээс гарч Шандуд ирсэн. Зуслангийн нь гоёмсог сайхан хот нэ-

гэнт эвдрэн шатсан учир тэнд удаан саатсангүй цааш явж Далай нуурын хөвөөн дахь Барс хотдоо очиж суусан түүхтэй билээ.

Хошууны төвд Шандын ундрал гэдэг сэтгүүл гарч, монголын түүхийн холбогдолтой олон сайхан материал нийтэлж байна. «Юаний дээд нийслэл» гэсэн хаягтай хар архийг Шандугийн туурь дээр онгойлгож мөнгөн аяганд хийж бид хоёрт барихад монголын уламжлалт сайхан заншил харагдаж байв. Шулуун хөх хошууны монголчууд зочломтгой хүмүүс юм. БНМАУ-ын иргэн Д. Зоригт бид хоёр Шулуун хөх хошуунд албан ёсоор зочилсон анхны зочид болсондоо баяртай байлаа. Хошууны дарга Дамбад бид баярласан сэтгэлээ илэрхийлж дахин уулзахын ерөөл дэвшүүлээд тэндээс мордов.